Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин<br>Эхний хагас жил | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 1. | Салбарын бодлого ба үйл ажиллагааг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд идэвхжүүлж, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Уулзалт, Хамтын ажиллагааны баримт бичиг, Айлчлал, Хуралдаан | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны удирдлагуудын гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, олон улсын байгууллагын тэргүүн, гадаад улсын асуудал эрхэлсэн сайд нар болон бусад гадаад улсын төлөөлөгчидтэй хийсэн 24 уулзалтыг зохион байгуулсан. Гадаад улс орнуудтай хамтын | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны удирдлагуудын Гадаад Улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, олон улсын байгууллагын тэргүүн, гадаад улсын асуудал эрхэлсэн сайд нар болон бусад гадны төлөөлөгчидтэй хийх 5 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны удирдлагуудын Гадаад Улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, олон улсын байгууллагын тэргүүн, гадаад улсын асуудал эрхэлсэн сайд нар болон бусад гадны төлөөлөгчидтэй хийх 7 удаагийн уулзалтыг зохион байгуулж, Гадаад улс орнуудтай хамтран ажиллах тухай хамтын ажиллагааны 5 баримт бичиг байгуулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх ажлын | 92.5 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны 6 баримт бичиг байгуулсан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх ажлын айлчлал болон Монгол Улсад хийх гадны зочид, төлөөлөгчдийн 11 айлчлалыг зохион байгуулсан. | удаагийн уулзалтыг зохион байгуулсан байна. Гадаад улс орнуудтай хамтран ажиллах тухай хамтын ажиллагааны 2 баримт бичиг байгуулсан байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх ажлын айлчлал болон Монгол Улсад хийх гадны зочид, төлөөлөгчдийн 2 удаагийн айлчлалыг зохион байгуулсан байна. Засгийн газар хоорондын хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг | айлчлал болон Монгол Улсад хийх гадны зочид, төлөөлөгчдийн 3 удаагийн айлчлалыг зохион байгуулсан. Засгийн газар хоорондын хуралдаан айлын талын саналаар хойшлогдсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэн ажилласан байна. | | |
| 1.1 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны удирдлагуудын гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, олон улсын байгууллагын тэргүүн, гадаад улсын асуудал эрхэлсэн сайд нар болон бусад гадаад улсын төлөөлөгчидтэй хийх уулзалтыг зохион байгуулах **СТХ 27.1.4 ССАЖЗЯ СЗ 8** | - | Уулзалтын тоо | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны удирдлагуудын гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, олон улсын байгууллагын тэргүүн, гадаад улсын асуудал эрхэлсэн сайд нар болон бусад гадаад улсын төлөөлөгчидтэй хийсэн 24 уулзалтыг зохион байгуулсан. | 3 удаагийн уулзалт зохион байгуулсан байна. | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол дахь Суурин зохицуулагч Яап ван Хиердан болон Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ина Марчюлёните-тэй 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хийсэн уулзалт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Минжуан-тай 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хийсэн уулзалт, ССАЖЗЯ-ны ТНБД С.Оюунбилэг Waagner Biro Stage Systems LLC-ын Монголыг хариуцсан Бизнес хөгжлийн хэлтсийн эдийн засагт Арьфред Гратфертэй 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хийсэн уулзалт, ССАЖЗЯ-ны ГХОУМСХАГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэнгүүн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Кэбэк мужийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын захирал Бард Нордбитэй 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн уулзалт, Австри Улсын Өргөмжит Консулын газрын төлөөлөгчидтэй 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн уулзалт, Бүгд Найрамдах Польш Улсад оршин суудаг Монгол цахим нөлөөлөгч Г.Гангамөрөнтэй 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хийсэн уулзалт зэрэг нийт 7 уулзалтыг амжилттай зохион байгууллаа. | |
| 1.2 | Гадаадын улс орнуудтай соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хамтран ажиллах тухай хамтын ажиллагааны баримт бичгүүд байгуулах **СТХ 27.1.4** **ССАЖЗЯ СЗ 8** | - | Байгуулсан баримт бичгийн тоо | Гадаад улс орнуудтай хамтын ажиллагааны 6 баримт бичиг байгуулсан. | Гадаад улс орнуудтай соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт хамтран ажиллах тухай хамтын ажиллагааны 1 баримт бичиг байгуулсан байна. | ИБУИНХАУ-ын мэргэжлийн хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубтэй 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдөр “Түншлэлийн гэрээ байгуулсан. Мөн “Чингис хаан Үндэсний музей болон Австрийн Шинжлэх ухааны академийн Иран судлалын хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”, “Соёлын солилцоо, хамтын ажиллагааны тухай | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Чингис хаан Үндэсний музей болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Солонгосын Үндэсний музей хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг", Чингис хаан Үндэсний музей болон БНХАУ-ын Өвөр Монголын Багшийн их сургууль хамтарсан "Эртний нүүдэлчдийн соёл, иргэншлийн археологийн судалгаа" төслийн гэрээ, "Монгол Улсын Чингис Хаан Үндэсний Музей болон Бүгд Найрамдах Герман Улсын Пруссын Соёлын Өвийн Сан, Берлин дэх Улсын Музейн харьяа Өвөг ба Эртний Түүхийн Музей хоорондын санамж бичиг", Монголын Үндэсний музей болон Киото их сургуулийн Хакүби судалгааны төвийн хооронд "Хүннүгийн үеийн чий будагтай үзмэрийг сэргээн засварлах" гэрээ зэрэг нийт 5 баримт бичгийг хянан Гадаад харилцааны яамнаас байгууллага хооронд гэрээ байгуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрлийг авч, холбогдох байгууллагад хүргүүлэв. | |
| 1.3 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх айлчлал болон Монгол Улсад хийх гадны зочид, төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулна. **СТХ 27.1.4** **ССАЖЗЯ СЗ 8** | - | Айлчлал | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх ажлын айлчлал болон Монгол Улсад хийх гадны зочид, төлөөлөгчдийн 11 айлчлалыг зохион байгуулсан. | Яамны төлөөлөгчдийн гадаад улсад хийх айлчлал болон Монгол Улсад хийх гадаад зочид, төлөөлөгчдийн ажлын 1 айлчлалыг зохион байгуулсан байна. | ССАЖЗЯ-ны ТЗУГ-ын дарга Ч.Энх-Амгалангийн 2025 оны 2 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо, ССАЖЗЯ-ны ТЗУГ-ын дарга С.Оюунбилэг болон МСХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цэзноров нарын 2025 оны 4 дүгээр сарын 2-7-ны өдрүүдэд ИБУИНХУ-ын Лондон хотод ажилласан. ССАЖЗЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Оюунбилэг болон МСХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цэзноров нарын БНФУ-ын Канн хотноо 2025 оны 6 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд зохион байгуулагдах Каннс Лайонс наадамд ажиллах томилолтын бэлтгэлийг хангаж ажиллаж байна. Түүнчлэн БНХАУ-ын Тяньжин хотын Төв телевизийн кино багийн Монгол Улсад 2025 оны 5 дугаар сарын 19-25-ны | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрүүдэд хийсэн Цайны замтай холбоотой баримтат киноны зураг авалтад дэмжлэг үзүүлэн ажилласан. | |
| 1.4 | Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. **СТХ 21.1.8** | - | Хуралдаан | - | Хуралдааны бэлтгэлийг хангасан байна. | Монгол-Тайландын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдааныг Тайландын талын хүсэлтээр 2025 оны 3-4 дүгээр улиралд зохион байгуулахаар хойшлуулаад байна. | 70 хувь |
| **Хоёр. Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубын сургалтад монгол хүүхдүүдийг хамруулна. **БТСТХ 11.1.17** | 150.0 | Сургалтад хамруулсан эсэх | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубын сургалтыг 2024 онд Улаанбаатар хотод зохион байгуулсан. | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубын сургалтад монгол хүүхдүүдийг хамруулсан байна. | ССАЖЗЯ-ны ТЗУГ-ын дарга С.Оюунбилэг болон МСХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цээноров нар 2025 оны 4 дүгээр сарын 2-7-ны өдрүүдэд ИБУИНХУ-ын Лондон хотноо ажиллаж, өсвөрийн 11 хөлбөмбөгчдийг Примьер лигийн Фулхэм клубын сургалтад хамруулах, тус клубын өсвөрийн багтай нөхөрсөг тоглолт зохион байгуулах, “Craven Cottage” цэнгэлдэх хүрээлэн болон Лондон хоттой танилцуулах ажлыг Фулхэм клуб болон Монгол Улсаас | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ИБУИНХАУ-д суугаа Элчин сайдын яамтай хамтран амжилттай зохион байгуулсан. Мөн энэ үеэр ТЗУГ-ын дарга С.Оюунбилэг Фулхэм клубын гүйцэтгэх захирал Алистар Макинтоштой уулзалт хийж Фулхэм клубтэй хэрэгжүүлж буй түншлэлийн талаар санал солилцов. | |
| **Гурав. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр улсын болон олон улсын хэмжээнд аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллана.** | | | | | | | |
| 3.1 | “Go Mongolia” сурталчилгааны арга хэмжээг зорилтот орнуудад зохион байгуулах **ЗГҮАХ 3.3.5.1, СТХ 27.1.4** | - | Арга хэмжээний тоо | Go Mongolia арга хэмжээг БНСУ-д зохион байгуулсан. | Арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна. | Швейцарын Холбооны Улсын Давос хотноо 2025 оны 01 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн эдийн засгийн форумын үеэр “Go Mongolia” үндэсний брэндийн дор зохион байгуулагдсан “Mongolia House” төслийн соёл, урлагийн арга хэмжээг хариуцан зохион байгуулж, тус форумд оролцсон 2000 орчим зочид, төлөөлөгчдөд Монгол Улсыг сурталчлан ажиллахад дэмжлэг үзүүлэв. | 100 хувь |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 1. Соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг сурталчлах ажлыг зохион байгуулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Олон улсад үзэсгэлэн гаргаж, Монгол Улсыг сурталчлах **СТХ 21.1.7, 27.1.4, ССАЖЗЯ-СТ-8.2** | 43.0 | Үзэсгэлэн | Япон зурагчин Сугияамагийн бүтээлээр гэрэл зургийн ном хэвлүүлсэн. | Канадын гэрэл зурагчдын бүтээлээр PDAC-2025 чуулга уулзалтын үеэр Монголыг сурталчилсан гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах чиглэлээр хамтран ажилласан байна. | Канад Улсын Торонто хотын “Пиэрсон” нисэх онгоцны буудалд Монголыг сурталчлах гэрэл зураг байршуулах гэрээ байгуулсны дагуу “Take Your Seat” төслийн хүрээнд Монголыг сурталчлах гэрэл зургийг Торонто хотын “Пиэрсон” нисэх онгоцны буудлын 1 дүгээр терминалд 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал байршуулсан. | 100 хувь |
| **1.2. Монгол Улсын дотоод, гадаад бодлого ардчилал шинэчлэлийн үйл явц Засгийн газрын бодлого шийдвэрийг таниулан сурталчлах, зөрөг зөв ойлголт төрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн засгийг тэлэх зорилтын хүрээнд Монгол Улсыг олон улсад сурталчлах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| | Монгол Улсын дотоод, гадаад бодлого ардчилал шинэчлэлийн үйл явц Засгийн газрын бодлого шийдвэрийг таниулан сурталчлах, зөрөг зөв ойлголт төрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн засгийг | 10,500,000,000 | Нэмэгдүүлсэн контентийн тоо, хандалтын тоо,сурталчилгаа хийсэн эсэх, Дэлхийн нэр хүндтэй томоохон компаниудтай гэрээ байгуулсан эсэх. | Монгол Улсыг олон улсад сурталчлах чиглэлээр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Би-Би-Си Телевиз болон тус улсын мэргэжлийн хөлбөмбөгийн Примьер Лигийн Фулхэм багтай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Мөн “Go Mongolia” брэндийг олон | Монгол Улсыг сурталчилсан контентийн тоог 15-аас доошгүй тоогоор нэмэгдүүлж, Монгол орныг сурталчлуулах арга хэмжээ зохион байгуулж, 50000-аас доошгүй хүнд хүргэн сурталчилсан | "Go Mongolia" Үндэсний брэндийг сурталчлан таниулж, Монголын соёл, урлаг, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын таатай орчин сэдвээр дамжуулан зөрөг ойлголтыг нэмэгдүүлэх, 2025 онд нийтдээ сурталчилгааны контент Си-Эн-Эн агентлаг 23 ширхэг, Трип дот ком 6 ширхэг, Фулхэм клуб 2 контент нийт 31 контентоор нэмэгдүүлж, Фулхэм клуб 90.3 сая + | 94 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэлэх зорилтын хүрээнд Монгол Улсыг олон улсад сурталчлах ажлыг зохион байгуулах | | | улсад сурталчлах ажилд ашиглагдах богино хэмжээний киног бүтээлгэх чиглэлээр Сингапур Улсын Хэклэр компанитай хамтран ажиллах гэрээг байгуулсан. | байна. 3-аас доошгүй дэлхийн нэр хүндтэй томоохон компаниудтай гэрээ байгуулсан байна.. | Трип дот ком 14,8 + Си-Эн-Эн 3,1 сая нийтдээ 108.2 сая үзэлтээр нэмэгдсэн. Си-Эн-Эн агентлагийн контентийн бэлтгэл хангагдаж III улиралд түгээгдэнэ. Фулхэм клубтэй 2025 - 2026 онуудад хамтран ажиллах гэрээг 2025.05.29-ний өдөр байгуулсан. Мөн Блүүмбэрг телевиз, Тик ток болон National Geographic зэрэг байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулахаар санал солилцон ажиллаж байна. | |
| 2.2.1 | Монгол Улсыг гадаадад сурталчлах чиглэлээр Блумберигтэй гэрээ байгуулна. **СТХ 27.1.4** | **875.0** | Сурталчилгааг түгээсэн эсэх | | Хамтран ажиллах талаар санал солилцож, гэрээ байгуулах боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангасан байна. | Блумбериг телевизийн төлөөлөгчидтэй уулзан хамтран ажиллах гэрээний нөхцөл, төлбөр болон хамтран ажиллах хүрээний талаар санал солилцсон бөгөөд одоогийн байдлаар эцэслэн тохироогүй байна. | 70 хувь |
| 2.2.2 | "Go Mongolia" Үндэсний брэндийг сурталчлах чиглэлээр Эдэлман Сингапур | 3,**500.0** | Хамтран ажилласан эсэх | Хамтран ажиллах гэрээнд 2024 онд гарын үсэг зурсан | Хамтран ажиллаж, сурталчлах, таниулах чиглэлээр | Эдэлман компанитай хамтран "Go Mongolia" брэндийг сурталчлан таниулах стратегийг (35 хуудас бүхий) | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Компанитай хамтран ажиллах **СТХ 21.1.7, 27.1.4** | | | | ажилласан байна. | боловсруулж, 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр төсөл хэлбэрээр танилцуулан , сайжруулалтын саналыг илгээсэн. Үүний дагуу дахин засаж, сайжруулан 2025 оны 5 дугаар сард ирүүлэв. Мөн гэрээний эхний төлбөр болох 500,000 а.долларын зарцуулалтын тайланг ССАЖЗЯ-нд ирүүлсэн. Мөн Монгол Улсыг олон улсад сурталчлах таниулах хүрээнд БНФУ-ын Канн хотноо 6 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд зохион байгуулагдах Каннс Лайонс наадамд оролцохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 2.2.3 | Монгол Улсыг гадаадад сурталчлах АНУ-ын Си-Эн-Эн Телевизтэй хамтран ажиллана. **СТХ 21.1.7, 27.1.4** | **4,375.0** | Сурталчилгаа түгээсэн эсэх | Хамтран ажиллах гэрээнд 2024 онд гарын үсэг зурсан | Монгол Улсыг сурталчлах сурталчилгааг түгээсэн байна. | Энэхүү гэрээний хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын эдийн засаг, ардчилал энх тайван, урлаг спорт, залуусын хөгжил, технологи инновац, хүсэл зорилгыг илэрхийлэх үндсэн сэдвийн хүрээнд 31 редакцын контент, 12 сурталчилгааны контент хийж, нийт 3,855 удаа эфирээр цацаж, интернет | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчинд 269 сая хандалт авсан. Дараагийн сурталчилгааны контентийн зураг авалт 2025 оны 7 дугаар сараас эхлэхээр төлөвлөж байна. | |
| 2.2.4 | Монгол Улсыг сурталчлах, аялал жуулчлалын салбарыг сурталчилгааг хийх чиглэлээр Трип дот ком групптэй хамтран ажиллах **АЖТХ 21.1.8, СТХ 27.1.4** | - | Сурталчилгааг түгээсэн эсэх | Хамтран ажиллах гэрээнд 2024 онд гарын үсэг зурсан | Монгол Улсыг сурталчлах сурталчилгааг түгээх чиглэлээр арга хэмжээ, төсвийн талаар санал солилцож, холбогдох бэлтгэл ажлыг хангасан байна. | Трип дот ком групп Монгол Улсыг сурталчлах ажлын хүрээнд Нэг минут найман секундын хугацаатай шууд дамжуулалт, БНХАУ-ын WeChat, Weibo суваг, БНСУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонконгийн цахим хуудсан дээр баннер байршуулж, 2025 оны 1 дүгээр сарын 2-15-ны өдрүүдийн байдлаар нийт 13,813,000 хүнд хүрсэн бөгөөд дараагийн шатны үйл ажиллагааны талаар санал солилцсон бөгөөд одоогийн байдлаар эцэслэн тохироогүй байна. | 100 хувь |
| 2.2.5 | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубтэй хамтарсан | **1,750.0** | Арга хэмжээний тоо | Хамтран ажиллах гэрээнд 2024 онд гарын үсэг зурсан | Сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна. | ИБУИНХУ-ын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клуб Фулхэм клубын албан ёсны халаалтын өмсгөлд “Go Mongolia” брэндийг байршуулсан бөгөөд тус | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчилгаа хөтөлбөр хэрэгжүүлэх **СТХ 27.1.4** | | | | | багийн өөрийн талбайдаа хийж буй бүх тоглолтын завсарлагааны үеэр нэг удаа 30 секундын сурталчилгааны видео болон талбайн дотор талын ЛЕД хашлагаар урсах сурталчилгааны самбарт 6 удаа 20 секундын "Go Mongolia" брэндийн сурталчилгааг түгээж, "Go Mongolia" брэнд нийгмийн сүлжээнд 90,3 сая хүнд хүрч, 10.1 сая хандалт авсан. Мөн "Go Mongolia' Always On" контент 22.8 сая цахим хандалттай, 428,000 сэтгэгдэл авсан тухай тайланг 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдөр ССАЖЗЯ-нд ирүүлсэн.<br>ИБУИНХУ-ын мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубтэй 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдөр талууд 2025-2026 онд хамтран ажиллах "Түншлэлийн гэрээ"-нд гарын үсэг зурсан. Фулхэм клубын холбогдох цахим сүлжээ, Примьер лигийн шууд дамжуулалтаар 2025 оны 8 дугаар сараас эхлэн "Go | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Mongolia" сурталчилгаа цацагдаж эхэлнэ. | |
| **Дөрөв. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 4.1.1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийн талаар сургалтад хамрагдах | - | Сургалтад хамрагдсан эсэх | Холбогдох сургалтад 2024 онд бүрэн хамрагдсан. | Холбогдох сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академийн Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цээноров 2025 оны 2 дугаар сарын 26-наас 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хооронд хамрагдаж, амжилттай төгслөө. | 100 хувь |
| 4.1.2 | Мэргэшүүлэх сургалтад хамрагдах | - | Сургалтад хамрагдсан эсэх | Холбогдох сургалтад 2024 онд бүрэн хамрагдсан. | Холбогдох сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академийн Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цээноров 2025 оны 2 дугаар сарын 26-наас 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хооронд хамрагдаж, амжилттай төгслөө. | 100 хувь |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.** "НҮБ-ын Аялал жуулчлалын | Арга хэмжээ | - | UN-TOURISM байгууллагаас зохион | Монгол Улсын Улаанбаатар хотноо 2025 оны 5 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан | 01-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого, стратегийн 19 дэх удаагийн Ази, Номхон далайн бүсийн удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах хөтөлбөр" арга хэмжээ | зохион байгуулах | | байгууллдаг цуврал бага хурал зохион байгуулсан байна. | "НҮБ-ын Аялал жуулчлалын бодлого, стратегийн 19 дэх удаагийн Ази, Номхон далайн бүсийн удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах хөтөлбөр" арга хэмжээг зохион байгуулж, МСХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Цээноров Монгол Улсын танилцуулга хийж, үндсэн оролцогчоор оролцов. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.** Туркменистан Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монгол, Туркменистаны хамтарсан урлагийн тоглолт зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулах | - | Туркменистан Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монгол, Туркменистаны хамтарсан тоглолт зохион байгуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар 2025 оны 6 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд хүрэлцэн ирсэн Туркменистан Улсын Ерөнхийлөгч Сердар Бердымухамедовын төрийн айлчлал үеэрх Монгол, Туркменистаны 80 гаруй уран бүтээлч хамтарсан хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллав. | 01-06 | 100% |
| 3 | **Арга хэмжээ 3.** Аялал жуулчлалын сургалтын төвийн нээлтийг зохион байгуулах | Арга хэмжээ зохион байгуулах | - | Аялал жуулчлалын сургалтын төвийн нээлтийг зохион байгуулсан байна. | НСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барьсан “Аялал жуулчлалын сургалтын төв”-ийн 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллав. | 01-06 | 100% |
| 4 | Дундаж оноо: | | | | | | 96.4% |

*Тайлагнасан:* **Р.Цээноров** *(огноо)*

Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........../ 2025.06.13

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

# ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ РЭНЦЭНЦОГТЫН ЦЭЭНОРОВЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ РЭНЦЭНЦОГТЫН ЦЭЭНОРОВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

Нэгжийн нэр: МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТЭС

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | 67,5 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | | 10 |
| 2. | Арга хэмжээ 2. | | 10 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 10. |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 12,5 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12,5 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12,5 |
| 4. | Манлайлах | 12,5 |
| 5. | Багаар ажиллах | 12,5 |
| 6. | Харилцаа | 12,5 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 12,5 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 67,5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 10 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 12,5. |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |

| | | |
|---|---|---|
| | (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) | |
| **Нийт оноо =** | | 90 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
*(албан тушаал)* ............................. *(гарын үсэг)* (С.ОЮУНБИЛЭГ) *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
*(албан тушаал)* ............................. *(гарын үсэг)* (Р.ЦЭЭНОРОВ) *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*